



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Батширээт сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ХЭА-2022/96/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чингис хот 2022 он	Тэргүүлэх аудитор:	Ч.Эрдэнэбаатар
	Утас:	70562112
	Аудитын менежер:	Д.Оюунтуяа
	Утас:	99775390
	Өндөрхаан итгэл аудит ХХК-ийн:	
	Аудитор:	Б.Маналсүрэн
	Утас:	99059424

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
3. Аудитын тайлан	6
3.1 Ерөнхий зүйл	6
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	6
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	6
3.4 Материаллаг байдал	7
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	7
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	8
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	9
3.8 Аудитын гол асуудал	9
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	9
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	10
4. Аудитын илрүүлэлт	10
4.1 Залруулсан алдаа	10
4.2 Төлбөрийн акт	10
4.3 Албан шаардлага	10
4.4 Зөвлөмж	10

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

дсдд.03 23 № 3д 6

танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Батширээт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хэнтий аймгийн Батширээт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант оны эцэст ажиллагсдын 4.5 сая төгрөгийн цалинг НДШ-ийн тайланд дутуу тайлагнасан, ажил олгогчоос төлөх 0.8 сая төгрөгийн НДШ-ийг цалингийн зардлаас төлсөн зэрэг зөрчлүүд нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйл. “Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэл төлөх үүрэг”, 17.1.1-д “Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх”, гэсэн заалт, УСНББОУС-1,2,12,24 холбогдох заалтуудтай нийцэхгүй тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

023030490

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

2021 оны 12 дугаар сарын 31

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	62,202,393.46	55,306,103.86
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
33	АВЛАГА	999.60	170,100.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	170,100.00
335	Бусад авлага	999.60	-
3351	Байгууллагаас авах авлага	999.60	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
34	УРЬДЧИЛГАА	-	-
3471	Урьдчилгаа тооцоо	-	-
34713	Цалингийн урьдчилгаа	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	62,201,393.86	55,136,003.86
351	Түүхий эд материал	-	-
35130	Эм боох материал	-	-
354	Хангамжийн материал	62,201,393.86	55,136,003.86
35410	Бичиг хэргийн материал	2,695,380.00	1,731,080.00
35420	Аж ахуйн материал	42,624,393.00	41,599,893.00
35440	Түлш, шатах тослох материал	9,585,000.00	-
35450	Барилгын засварын материал	-	-
35460	Хүнсний материал	4,567,640.00	9,076,050.00
35470	Бусад хангамжийн материал	2,728,980.86	2,728,980.86
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	276,607,895.04	266,348,918.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	276,607,895.04	266,348,918.69
392	Биет хөрөнгө	226,645,895.04	216,386,918.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	217,536,393.16	217,536,393.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	(12,754,535.04)	(19,382,947.74)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	28,857,099.99	28,857,099.99
39206	Хуримтлагдсан элэгдэл	(10,618,726.35)	(13,138,584.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,783,921.39	27,783,921.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,158,258.11)	(25,268,963.75)
39214	Бусад үндсэн хөрөнгө	400,000.00	400,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(400,000.00)	(400,000.00)
39217	Ном	-	-
393	Биет бус хөрөнгө	49,962,000.00	49,962,000.00
39301	Програм хангамж	66,500.00	66,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(66,500.00)	(66,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	49,962,000.00	49,962,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	338,810,288.50	321,655,022.55
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	185,509.00	257,059.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	185,509.00	257,059.00
413	Өглөг	185,509.00	257,059.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	185,509.00	257,059.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	338,624,779.50	321,397,963.55
51	Засгийн газрын хувь оролцоо	338,624,779.50	321,397,963.55
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	429,763,859.88	429,763,859.88
51101	Өмч - төрийн	429,763,859.88	429,763,859.88
512	Хуримтлагдсан үр дүн	(97,441,360.38)	(114,668,176.33)
51210	Өмнөх үеийн үр дүн	(97,441,360.38)	(97,441,360.38)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(17,226,815.95)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,302,280.00	6,302,280.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	338,810,288.50	321,655,022.55

Батширээт сумын цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	280,314,600.00	253,072,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,652,100.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	7,652,100.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,652,100.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,652,100.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	272,662,500.00	253,072,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	244,492,300.00	223,555,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлэгээс санхүүжих	244,492,300.00	223,555,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	140,000.00	169,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	114,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	140,000.00	55,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,030,200.00	29,347,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,030,200.00	29,347,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	277,745,026.34	270,299,415.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	277,745,026.34	270,299,415.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	243,361,838.78	250,319,452.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	175,348,513.00	175,114,946.11
210101	Үндсэн цалин	131,537,404.00	162,055,389.11
210102	Нэмэгдэл	20,613,768.00	-
210104	Урамшуулал	14,885,593.00	13,059,557.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,311,748.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,478,083.34	23,647,756.40
210201	Тэтгэврийн даатгал	17,621,729.66	17,742,492.51
210202	Тэтгэмжийн даатгал	1,217,237.92	2,343,641.29
210203	ҮОМЦНӨ-ний даатгал	970,430.74	949,873.00
210204	Ажил үйлдлийн даатгал	242,607.18	237,368.20
210205	Эрүүл мэндийн даатгал	2,426,077.84	2,374,381.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,525,753.24	23,114,283.99
210301	Гэрэл, цахилгаан	2,490,073.24	2,165,621.99
210302	Түлш, халаалт	18,963,680.00	20,948,662.00
210303	Цэвэр, бохир ус	72,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	1,586,730.00	4,311,400.00
210401	Бичиг хэрэг	69,000.00	1,910,600.00
210402	Тээвэр, шатахуун	266,040.00	49,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	695,200.00	735,200.00
210404	Ном, хэвлэл	26,640.00	-
210405	Хөг хаягдал зайлуулах, хортон мөргөчдийн устгал, ариутгал	120,000.00	220,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	409,850.00	925,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	471,400.00
210408	Бараа материал акталсны зардал	-	-
2105	Нормативт зардал	14,196,410.00	11,031,590.00
210501	Ом, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-
210502	Хоол, хүнс	14,196,410.00	10,915,990.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	115,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	485,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210604	Урсгал засвар	-	485,000.00
2107	Томилголт, зочны зардал	-	69,000.00
210702	Дотоод албан томилголт	-	69,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,000.00	324,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,902,349.20	12,221,476.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дэдлага хийх	1,297,400.00	1,962,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,604,949.20	10,258,976.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,383,187.56	19,979,963.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	300,000.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,938,126.76	16,220,726.01
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,938,126.76	16,219,726.01
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,045,060.80	3,459,237.09
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,045,060.80	3,459,237.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,569,573.66	(17,226,815.95)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,569,573.66	(17,226,815.95)

Батширээт сумын дэвсгэр

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	429,763,859.88	6,302,280.00	(100,010,934.04)	336,055,205.84
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	429,763,859.88	6,302,280.00	(100,010,934.04)	336,055,205.84
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	2,569,573.66	2,569,573.66
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	429,763,859.88	6,302,280.00	(97,441,360.38)	338,624,779.50
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	429,763,859.88	6,302,280.00	(97,441,360.38)	338,624,779.50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	429,763,859.88	6,302,280.00	(97,441,360.38)	338,624,779.50
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(17,226,815.95)	(17,226,815.95)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	429,763,859.88	6,302,280.00	(114,668,176.33)	321,397,963.55

Батширээт сумын цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	272,662,500.00	253,072,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	272,662,500.00	253,072,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	244,492,300.00	223,555,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	244,492,300.00	223,555,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	140,000.00	169,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	114,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	140,000.00	55,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,030,200.00	29,347,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,030,200.00	29,347,900.00
1330	Төсвийн захирагчдаас	-	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	272,662,500.00	253,072,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	272,662,500.00	253,072,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	238,279,312.44	233,092,636.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	176,608,282.88	176,219,071.90
210101	Үндсэн цалин	124,656,859.52	114,593,977.08
210102	Нэмэгдэл	27,682,689.36	32,791,781.51
210104	Урамшуулал	14,885,593.00	13,059,054.19
210105	Гэрээт ажлын хөлс	9,383,141.00	15,774,259.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,241,446.32	22,641,181.01
210201	Тэтгэврийн даатгал	15,624,249.32	16,062,860.69
210202	Тэтгэмжийн даатгал	1,654,350.00	1,644,636.33
210203	ҮОМЦӨ-ний даатгал	1,323,439.00	1,315,425.30
210204	Ажилгүйдлийн даатгал	330,809.00	328,887.03
210205	Эрүүл мэндийн даатгал	3,308,599.00	3,289,371.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,747,073.24	13,128,173.99
210301	Гэрэл, цахилгаан	2,490,073.24	2,165,621.99
210302	Туш, халвалт	22,185,000.00	10,962,552.00
210303	Цэвэр, бохир ус	72,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	4,217,110.00	2,165,310.00
210401	Бичиг хэрэг	1,086,700.00	230,500.00
210402	Тээвэр, шатахуун	697,720.00	450,310.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	695,200.00	964,000.00
210404	Ном, хэвлэл	26,640.00	46,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	220,000.00
210406	Бага үнэтэй, түргэн эзлэгдэх, ахуйн эд зүйлс	1,590,850.00	254,500.00
2105	Нормативт зардал	6,853,400.00	15,930,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	48,700.00
210502	Хөөц, хуны	4,208,400.00	15,424,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,645,000.00	457,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	485,000.00	114,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210602	Тавилга		
210604	Урсгал засвар	485,000.00	114,400.00
2107	Томилот, зочны зардал	-	69,000.00
210702	Дотоод албан томилот	-	69,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,000.00	324,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,803,000.00	2,501,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,803,000.00	2,501,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,383,187.56	19,979,963.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн гэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	300,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,938,126.76	16,220,726.01
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,938,126.76	16,219,726.01
213405	Хөрөнгийн		1,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,045,060.80	3,459,237.09
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,045,060.80	3,459,237.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайланг оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, гүүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	252,903,200.00	233,224,236.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	252,903,200.00	233,224,236.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	252,603,200.00	232,924,236.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшилт	179,026,100.00	176,219,071.90
210101	Үндсэн цалин	126,422,900.00	114,593,977.08
210102	Нэмэгдэл	23,066,700.00	32,791,781.51
210104	Урамшуулал	17,353,600.00	13,059,054.19
210105	Гэрээт ажлын хөлс	12,182,900.00	15,774,259.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,818,500.00	22,041,181.01
210201	Тэтгэврийн даатгал	16,057,500.00	16,062,860.69
210202	Тэтгэмжийн даатгал	1,690,200.00	1,644,636.33
210203	ҮОМШО-ний даатгал	1,352,200.00	1,315,425.30
210204	Ажилгүйдлийн даатгал	338,000.00	328,887.03
210205	Эрүүл мэндийн даатгал	3,380,600.00	3,289,371.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,262,700.00	13,128,173.99
210301	Гэрэл, цахилгаан	2,700,000.00	2,165,621.99
210302	Түлш, халаалт	23,562,700.00	10,962,552.00
210303	Цэвэр, бохир ус		
2104	Хангамж, бараа материалын зардал	2,405,900.00	2,111,310.00
210401	Бичиг хэрэг	86,700.00	176,500.00
210402	Тээвэр, шатахуун	700,000.00	450,310.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,070,200.00	964,000.00
210404	Ном, хэвлэл	53,000.00	46,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, арнуга	240,000.00	220,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	256,000.00	254,500.00
2105	Нормативт зардал	15,962,800.00	15,930,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	48,700.00	48,700.00
210502	Хоол, хүнс	15,446,600.00	15,424,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	467,500.00	457,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,085,200.00	-
210601	Багаж, техник хэрэгсэл		
210604	Урсгал засвар	3,085,200.00	-
2107	Төмилөлт, зочны зардал	88,500.00	69,000.00
210702	Дотоод албан төмилөлт	88,500.00	69,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураам	324,000.00	324,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,629,500.00	2,501,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	128,500.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,501,000.00	2,501,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00	300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	252,903,200.00	233,224,236.90
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	223,555,300.00	220,096,062.91
131007	Тусгай зориулалтын нийгэмлэгүүдөөс санхүүжих	223,555,300.00	220,096,062.91
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	29,347,900.00	13,128,173.99
132001	Орон нутгийн төсвөөс	29,347,900.00	13,128,173.99

Батширээт сумын цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

2021 оны 12 дугаар сарын 31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	169,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	169,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	168,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	54,000.00
210401	Бичиг хэрэг	-	54,000.00
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хөг хаягдал зайлуулах, хөргөн мэрэгчдийн усгал, ариутгал	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	114,400.00
210604	Урсгал засвар	-	114,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,000.00
2134	Өлгөсөн санхүүжилт, шилжүүлэг	-	1,000.00
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	169,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	169,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	114,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	55,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Батширээт сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өндөрхаан итгэл аудит ХХК-ийн аудитор П.Мөнгөнтуул, аудиторын туслах Ж.Батсайхан нар гүйцэтгэж, хяналтыг компанийн захирал, аудитор Б.Маналсүрэн, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Батширээт сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өндөрхаан итгэл аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Батширээт сумын Цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг Сургуулийн өмнөх насны боловсролын тухай хуулиар дараах байдлаар тодорхойлжээ.Үүнд:

“Бага насны хүүхдийг өөрийн онцлог,чадвар,бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах,хамгаалах,хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэж заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Батширээт сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 277,745.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,777.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2,222.0 мянган төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж 2,162.3 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Батширээт сумын Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17,155.3 мянган төгрөгөөр буюу 5.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөг/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	1.00	170.10	169.10
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	62,201.40	55,136.00	(7,065.40)
Үндсэн хөрөнгө	276,607.90	266,348.90	(10,259.00)
Нийт хөрөнгө	338,810.30	321,655.00	(17,155.30)
Өр төлбөр	185.50	257.00	71.50
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	338,624.80	321,398.00	(17,226.80)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	429,763.90	429,763.90	-
Хуримтлагдсан үр дүн	(97,441.40)	(97,441.40)	-
Тайлант үеийн үр дүн		(17,226.80)	(17,226.80)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,302.30	6,302.30	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	338,810.30	321,655.00	(17,155.30)

Тайлант онд авлага 169.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн.

Бараа материалын дансны үлдэгдэл нь 55,136.0 мянган төгрөг болж 7,065.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 23,500.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 30,565.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, шатах тослох материал 9,585.0 мянган төгрөгөөр буурсанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 266,348.9 мянган төгрөг болж 10,259.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд үндсэн хөрөнгийн 16,618.9 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар хорогдсонтой холбоотой.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл алдагдал 114,668.2 мянган төгрөг болж, 17,226.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант хугацааны үр дүнгийн өсөлт нөлөөлсөн байна.

Урьд оны 71.5 мянган төгрөгийн өглөгийг барагдуулсан байна.

Хэнтий аймгийн Батширээт сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 27,242.0 мянган төгрөгөөр буюу 9.7 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй авсан орлого 7,652.1 мянган төгрөг, санхүүжилтийн орлого 19,589.9 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 7,461.0 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлуудыг авч үзвэл тээвэр шатахууны зардал 266.0 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардал 3,164.8 мянган төгрөгөөр буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 383,382.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 130,479.0 мянган төгрөгөөр бууруулан нийт зарлагыг 252,903.2 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: цалингийн зардлыг 62,106.2 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 8,528.7 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 15,446.6 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 252,903.2 мянган төгрөгөөр баталсанаас 223,555.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 29,347.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 223,555.3 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 29,347.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, урсгал үйл ажиллагаанд

233,224.2 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 16,219.7 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 3,459.3 мянган төгрөгийг тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 233,224.2 мянган төгрөг буюу 92.2 хувьтай байгаа нь түлш халаалтын зардлыг 12,600.2 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 114.4 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 55.0 мянга, нийт 169.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэн, 168.4 мянган төгрөгийг зарцуулж, 1.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал илрээгүй.

3.8 Аудитын гол асуудал

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны сайтад оруулбал зохих 144 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн тул өгөгдсөн зөвлөмж байхгүй.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,657.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 355.6 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 5,302.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай нийт 355.6 мянган төгрөгийн 1 алдааг залрууллаа. Үүнд:

Өмнөх оны 185.5 мянган төгрөгийн өглөгийг барагдуулаагүй цалингийн зардалд бичиж хаасан. Мөн тайлант онд 170.1 мянган төгрөгийн авлагыг бүртгээгүй байсныг тус тус залруулав.

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

4.3.1 Ажил олгогчоос төлөх 796.7 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг эдийн засгийн ангилал зөрүүлж цалингийн зардлаас төлсөн.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4.3.2 Тайлант хугацаанд ажиллагсдад олгосон цалинг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд тайлагнахдаа 4,505.5 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4.4 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Батширээт сумын Цэцэрлэг	3	5657,8	1	355.6			2	5,302.2		
	Дүн	3	5657,8	1	355.6			2	5,302.2		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 23

Дугаар 226/23910610
ХЭА 2022/96/НА СТА ТШС

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Батширээт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд ажиллагсдад олгосон цалинг НДШ-ийн тайланд тайлагнахдаа 4,505.5 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйл. "Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэл төлөх үүрэг", 17.1.1-д "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. НДШ-ийн тайланг үнэн зөв тайлагнадаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Батширээт сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч А.Хандцоо, нягтлан бодогч Б.Энхтөр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨНДӨРХААН ИТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Б.МАНАЛСҮРЭН

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА

2317144297
СЮА0046 9074082



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 23

Дугаар 227/23910610
ХТН 2022/96/НА СТА ТЦС

Чингис хот

Г Зөрчил арилгах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Батширээт сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажил олгогчоос төлөх 796.7 мянган төгрөгийн НДШ-ийг цалингийн зардлаас төлж, батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8 “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулдаггүй зөрчлийг арилган, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Батширээт сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч А.Хандцоо, нягтлан бодогч Б.Энхтөр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨНДӨРХААН ИТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИВАЛ

Б.МАНАЛСҮРЭН

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА

